



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 145

Номгон

Г “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах”  
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, үр дүнг тооцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 132 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190258

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны  
өдрийн 145 дугаар тогтоолын хавсралт

**“ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ  
ХАНГАХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**  
/2019-2022/

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

Жендэрийн тэгш байдал нь хөгжлийн чухал зорилт бөгөөд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулахад ихээхэн хувь нэмэр оруулдаг. Жендэрийн тэгш байдлыг хангах нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн аль алиных нь ашиг сонирхол, хэрэгцээнд эерэгээр нөлөөлдөг төдийгүй ирээдүй хойч үедээ хийж буй хөрөнгө оруулалт юм.

Аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийнхээ хүрээнд орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй болгох, жендэрийн тэгш байдал хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх, бодлогын үр нөлөөг үнэлэх “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэс болно.

Монгол Улсын төдийгүй дэлхийн олон улс орнуудад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад цалин хөлсгүй гэрийн ажил хийх, албан бус салбарт хөдөлмөр эрхлэх нь элбэг байна. Малчин эсвэл жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч ялгаагүй илүү өгөөжтэй хөрөнгө эзэмших боломж хомс байгаа нь тэдний ажлын бүтээмж, үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, шийдвэр гаргах түвшин дэх төлөөлөл хангалттай бус байна. Түүнчлэн жендэрт суурилсан хүчирхийлэл тэр дундаа гэр бүлийн болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нийгэмд буурахгүй хурцадмал асуудал болсоор байна. Иймээс Дэлхийн улс орнууд Тогтвортой Хөгжлийн Зорилтыг хэлэлцэн, 2030 он хүртэл түүний нэг зорилтыг Жендэрийн тэгш байдлыг хангах асуудал хэмээн үзэж баталсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 20, 34 дүгээр тогтоолоор аймгийн Жендэрийн салбар хороог байгуулж үйл ажиллагааны журмыг баталсан.

Жендэрийн салбар хороо нь улсын хэмжээнд 2018 оны шилдэг салбар хороогоор шалгарсан бөгөөд үндэсний хэмжээнд дэд хөтөлбөрөө батласан анхны аймаг юм.

Аймгийн хэмжээнд Жендэрийн салбар хороо, дэд хөтөлбөр хэрэгжүүлэх баг, сумын хүн амын хөгжлийн салбар хорооны бүтэцтэйгээр хууль, үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийт ажиллагсдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байгаач, удирдах, шийдвэр гаргах түвшинд харьцангуй бага байна.

Тухайлбал аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 24.3 хувь, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 22.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

Аймгийн хэмжээнд нийт төрийн албан хаагчдын 30.4 хувийг эрэгтэйчүүд, 69.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Удирдах албан тушаалтныг албан тушаалын ангиллаар нь авч үзвэл: Улс төрийн албан тушаалтны 15.4 хувь, төрийн захиргааны албан тушаалтны 41.3 хувь, төрийн үйлчилгээний албан тушаалтны 75 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2014 онд эмэгтэй хүний дундаж наслалт 75.4, эрэгтэй хүнийх 65.9 байсан нь 2018 онд эмэгтэй хүнийх 70.5 эрэгтэй хүнийх 65.5 болж дундаж наслалт эмэгтэй хүнийх 4.9, эрэгтэй хүнийх 0.4 насаар буурчээ.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах асуудалд хандах олон нийтийн хандлага сайжирч байна. Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 5 сарын байдлаар 207 нас баралт байгаагийн 59 /123/ хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн нас баралтын 62 хувийг зүрх судасны өвчлөл эзлэж байна. Хорт хавдрын нас баралт 39 түүнээс эрэгтэйчүүд 58 хувь, осол гэмтлийн нас баралт 25 үүнээс эрэгтэйчүүд 72 хувийг эзлэж байна. Эмэгтэйчүүдтэй харьцуулахад (10 000 хүн тутамд) эрэгтэйчүүдийн амиа хорлох үзэгдэл, хүчирхийлэл үйлдэх хандлага ихсэж, зам тээврийн осолд өртөх тохиолдол 1.5 дахин өндөр байна.

Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг зөрчлийн мэдээгээр 2019 оны эхний 5 сарын байдлаар хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.3 дахин, хүний амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 25 хувиар өсч гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 3, эмэгтэй хүн оролцсон 5, хүүхэд оролцсон гэмт хэрэг 7-оор тус тус буурсан байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв” Аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээг 78 хүнд үзүүлсэн. Үүнээс: 30 эмэгтэй, 48 хүүхэд /20 эрэгтэй, 28 эмэгтэй/ байрласан байна. 52 хүүхэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. /21 эрэгтэй, 31 эмэгтэй/ Хамгаалах байранд байрласан болон НЦҮТөөвс зөвлөгөө авчээ.

Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, түүний дотор нөхөн үржихүйн насны болон бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг ажилд авах сонирхолгүй байх, эмэгтэйчүүдийг эрт тэтгэвэрт гаргах үзэгдэл түгээмэл байна.

Хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчин боловсронгуй болж, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр ахиц, дэвшил гарч байгаа боловч хууль хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх, санхүүжилтийг хүрэлцээтэй хуваарилах, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал байсаар байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг өргөн хүрээнд авч үзэх гэр бүлийн боловсрол олгох, нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх чиглэлээр анхааран ажиллах шаардлага тулгарч байна. Орон нутгийн түвшинд жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхийн тулд байгууллагууд бие биенээ дэмжсэн цогц зохицуулалт бий болгох, харилцан туршлага солилцох замаар хүний нөөцийг чадавхжуулах хэрэгцээ байна.

Улс төрийн намууд бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээг дүрмээрээ тогтоож байгаа хэдий ч орон нутагт шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо төдийлөн хангалттай сайжрахгүй байна.

Иймд НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 оны Эх дэлхийгээ шинэчилье, 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн 5 дугаар зорилт, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх зорилт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулав.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

### **2.1. Хөтөлбөрийн зорилго**

Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөх, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах.

## **2.2. Хөтөлбөрийн зорилт**

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлнэ:

2.2.1. Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог бэхжүүлж, түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх;

2.2.2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх;

2.2.3. Жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх;

## **2.3. Хөтөлбөрийн хугацаа**

Хөтөлбөрийг 2019-2022 онд хэрэгжүүлнэ.

## **2.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

**Зорилтын 1-ийн хүрээнд:** Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог бэхжүүлж, түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх;

1.1 Орон нутгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх аймгийн салбар хороо, сумын хүн амын хөгжлийн асуудлаарх салбар хороодын гишүүдийг чадавхжуулж мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

1.2 Аймгийн Жендэрийн салбар хорооны дэргэд жендэрийн шинжээч, зөвлөх, хэвлэл мэдээллийн зөвлөлийн баг байгуулж үйл ажиллагааг дэмжих;

1.3 Аймгийн Засаг даргатай байгуулж буй агентлаг, сумын Засаг даргын үр дүнгийн гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгах;

1.4 Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд тусгуулан хэрэгжилтийг үнэлэх;

1.5 улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх;

**Зорилтын 2-ын хүрээнд:** Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх;

2.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг орон нутгийн

хэмжээнд хэлэлцүүлэх, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгах арга хэмжээ авах;

2.2 Иргэдийн газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгах;

2.3 Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвх болон оролцоо, тэднийг үнэлэх үнэлэмж, хандлага, гэр бүлийн хүрээнд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийж гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгуулах арга хэмжээ авах;

2.4 Гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх арга хэмжээг дэмжиж, орон нутагт ажиллах нөхцлөөр ханган, зөвлөгөө өгөх бүтэц, хүний нөөцийг бэлтгэх;

2.5 Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, орон нутгийн сургагч багш бэлтгэх;

**Зорилтын 3-ийн хүрээнд:** Жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх;

3.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэгийн болон бага ангийн багш), эрүүл мэнд (эмч, сувилагч, асрагч)-ийн чиглэлээр суралцах эрэгтэйчүүд, мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцах эмэгтэйчүүдийг нэмэгдүүлэх;

3.2 Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах;

3.3 Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, жендэрийн асуудлаар тусгайлсан нийтлэл, нэвтрүүлгийг тогтмол гаргах, нийгэм дэх манлайлагч, олны танил эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн эрэгтэйчүүдийн ололт, амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх.

3.4 Эрэгтэйчүүд, ялангуяа 18-35 насныханд зориулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.5 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэн урамшуулах;

3.6 Аж ахуйн нэгж, байгууллагад хүчирхийлэл, түүний дотор ажлын байр дахь бэлгийн дарамт гарахаас сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх

3.7 Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж (Нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байр зэрэг)-ийн үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлэх

3.8 Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах дэмжих;

### Гурав. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

#### 3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ:

3.1.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган бүтэц бий болно.

3.1.2. Жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдөж оролцоо нэмэгдэнэ.

3.1.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавх бэхэжсэн байна.

3.1.4 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэн байна.

#### 3.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2018 он)	Дунд хугацаанд үнэлэх түвшин (2020 он)	Зорилтот түвшин (2022 он)	Мэдээллийн эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллагууд
1	Хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх асуудлыг дотоод журамдаа тусгасан байгууллага, <b>аж ахуйн нэгжийн тоо</b>	хувь	2.7	20	35	ЖСХорооны тайлан	АЗДТГ
2	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинет	тоо	0	1	1	ЭМГ-ын тайлан	ЭМГ
3	Жендэрийн сургагч багшийн тоо	тоо	22	32	50	ЖСХорооны тайлан	АЗДТГ
4	Жендэрийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан (УА)	тоо	89	130	200	ЖСХорооны тайлан	АЗДТГ ТАЗөвлөл

	Жендэрийн сургалтад хамрагдсан төрийн хаагч (ТАХ)	албан	тоо	800	1500	2900	ЖСХорооны тайлан	
5	МСС-ын материалын төрөл	тоо	ш	3 төрөл 3200	6 төрөл 5000	9 төрөл 3200	ЖСХорооны тайлан	АЗДТГ Сутгүүлчдийн холбоо

**Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр,  
шаардагдах хөрөнгийн хэмжээ**

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

4.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

4.1.2. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

4.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

4.1.4. бусад эх үүсвэр.

**Тав. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт,  
хяналт-шинжилгээ, үнэлгээ**

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг байгуулах, салбар дундын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих, үр дүнд үнэлгээ хийх чиг үүргийг жендэрийн салбар хороо, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хариуцан гүйцэтгэнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах, тэдний санал санаачилгыг дэмжин хамтарч ажиллах, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр гаргах, олон нийтэд мэдээлэх үүргийг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хариуцна.